



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER


- [f facebook.com/Rtcc.m0n](https://www.facebook.com/Rtcc.m0n)
- <http://rtcc.mrtd.gov.mn>
- info@rtcc.mrtd.gov.mn
- +976 77244409

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН
2020 оны 08 дугаар сарын дугаар



Суурь бүтцийн 2020 оны 7-р сарын хөдөлгөөний зурмагийн тасалдлын судалгаа тайлан

2020 оны 7-р сард нийтдээ 125 удаагийн зурмаг тасалдал бүртгэгдсэнээс:



Суурь бүтцийн 2020 оны 7-р сарын нийт тасалдлыг 2019 оны мөн үетэй харьцуулан үзэхэд 55 нэгж буюу **30.56%** -иар буурсан үзүүлэлттэй байна.



Зорчигчийн галт тэрэгний явуулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулан үзэхэд 9 нэгж буюу **64.29%** -иар буурсан үзүүлэлттэй байна.



Зорчигчийн галт тэрэгний явуулалт 7 дугаар сар

д/д	Өртөөний нэр	Галт тэрэгний тоо		
		төлөвлөсөн	биелсэн	тасалдсан
1	Сүхбаатар			1
2	Дархан			1
3	Шарын гол			0
4	Эрдэнэт			1
5	Зүүнхараа			1
6	Улаанбаатар			1
7	Айраг			0
8	Бор-Өндөр			0
9	Сайншанд			0
10	Замын-Үүд			0
Бүгд				5



Суурь бүтцийн 2020 оны 7-р сарын хөдөлгөөний зурмагийн тасалдлын судалгаа тайлан

Зорчигчийн галт тэрэгний өнгөрүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад тасалдлын тоо 15 нэгж буюу 53.57%-иар буурсан үзүүлэлттэй байна.




Зорчигчийн галт тэрэгний өнгөрүүлэлт 7 дугаар сар				
Д/д	Өртөөний нэр	Галт тэрэгний тоо		
		төлөвлөсөн	биелсэн	тасалдсан
1	Сүхбаатар – Улаанбаатар			7
2	Дархан – Улаанбаатар			1
3	Дархан – Шарын гол			0
4	Дархан – Эрдэнэт			0
5	Зүүнхараа – Улаанбаатар			2
6	Айраг – Бор-Өндөр			0
7	Улаанбаатар – Сайншанд			0
8	Улаанбаатар – Замын-Үүд			3
Бүгд				13

Ачааны галт тэрэгний явуулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад тасалдлын тоо 13 нэгж буюу 40.63% -иар буурсан үзүүлэлттэй байна.



Ачааны галт тэрэгний явуулалт (7 дугаар сар)				
Д/д	Өртөөний нэр	Галт тэрэгний тоо		
		төлөвлөсөн	биелсэн	тасалдсан
1	Сүхбаатар			7
2	Ерөө			1
3	Дархан-1			0
4	Дархан-2			1
5	Шарын гол			1
6	Салхит			0
7	Хөтөл			0
8	Эрдэнэт			1
9	Зүүнхараа			3
10	Толгойт			1
11	Улаанбаатар-1			0
12	Улаанбаатар-2			4
13	Алгалан			0
14	Багахангай			0
15	Маянт			0
16	Багануур			0
17	Цойр			0
18	Шивээ-Овоо			0
19	Олон-Овоо			0
20	Айраг			0
21	Бор-Өндөр			0
22	Өргөн			0
23	Зүүнбаян			0
24	Улаан-Уул			0
25	Сайншанд			0
26	Замын-Үүд			0
Бүгд				19





Суурь бүтцийн 2020 оны 7-р сарын хөдөлгөөний зурмагийн тасалдлын судалгаа тайлан


Ачааны галт тэрэгний өнгөрүүлэлтийг өмнөх сартай харьцуулахад тасалдлын тоо 18 нэгж буюу 16.98% -иар буурсан үзүүлэлттэй байна.



Ачааны галт тэрэгний өнгөрүүлэлт (7 дугаар сар)				
д/д	Өргөөний нэр	Галт тэрэгний тоо		
		төлөвлөсөн	Биелсэн	тасалдсан
1	Сүхбаатар – Зүүнхараа			13
2	Сүхбаатар – Дархан			1
3	Ерөө – Зүүнхараа			3
4	Дархан – Шарын гол			0
5	Дархан – Сайхот			0
6	Дархан – Зүүнхараа			2
7	Салжит – Эрдэнэт			2
8	Зүүнхараа – Улаанбаатар			23
9	Улаанбаатар – Багануур			2
10	Улаанбаатар – Чойр			16
11	Багахангай – Чойр			0
12	Багахангай – Улаанбаатар			1
13	Багахангай – Багануур			0
14	Чойр – Сайншанд			10
15	Айраг – Бор-Өндөр			0
16	Сайншанд – Зүүнбаян			1
17	Сайншанд – Замын-Үүд			14
Бүгд				88

Нийт 125 тасалдал бүтгэгдсэнээс хамгийн их буюу 69 нэгжийг зүтгүүрийн гэмтлээс үүдсэн тасалдал эзэлж байна.

Зүтгүүртэй холбоотой 69 тасалдалын 36 (52.17%) нэгжийг 2ТЭ116УМ серийн зүтгүүр, 9 (13.04) нэгжийг 2ЗАГАЛ серийн зүтгүүр, 6 (13.04%) нэгжийг 2ТЭ25КМ, 2ТЭ116УД, 2М62ММ, 2ТЭ-116 серийн зүтгүүрүүд нь тус тус эзэлж байна.



Нийтдээ хохирлын хэмжээ 26'790'482₮ болсон байна. Үүнээс зүтгүүрийн гэмтэл болон зүтгүүрийн гэмтлээс үүдэлтэй саатсан хохирлын хэмжээ 15'325'316 (57.21%) төгрөг, хоорондын замд саатсан галт тэргийг хүлээн зогсож зурмагаас гарсан тасалдлын хохирлын хэмжээ 2'559'823 (9.55%) төгрөг эзэлж байна.

Мөн технологийн зөрчил буюу ажилчдын буруутай үйлдлээс үүдсэн тасалдлын хохирлын хэмжээ 1'346'153 (5.02%) төгрөг, төмөр замын гарам, төмөр зам дээр хүн, машин, мал байсан болон дайрагдсанаас шалтгаалан гарсан тасалдлын хохирлын хэмжээ 4'297'040 (16.04%) төгрөг, бүхээгний аюулгүй байдлын систем (БАБС)-ийн доголдлоос үүссэн тасалдлын хохирлын хэмжээ 732'932 (2.74%) төгрөг, бусад шалтгаантай тасалдлын хохирлын хэмжээ 2'529'218 (4%) төгрөг, болж тус тус эзэлж байна.

Мэдээ, мэдээлэл



"Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.



Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны даргын тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу 2020 оны 07 дүгээр сарын төмөр замын тээврийн тээвэрлэлтийн мэдээг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогыг хэрэгжүүлэх газар, Бодлого төлөвлөлтийн газарт хүргэж танилцуулсан.

2020 оны 07 дүгээр сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа, зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч, ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны www.mrtcc.gov.mn цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ.



Хөдлөх бүрэлдэхүүний судалгаа


Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүн бүртгэл хөтлөх, хүлээлцэх журамд хөдлөх бүрэлдэхүүн түрээстэй холбоотой заалт оруулсан. 2020 оны 05 дугаар сарын 28 ны өдөр захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж цааш нь нэмж судлах үүрэг авч ажилласан. 2020 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн №130 албан бичгээр орон нутгийн болон экспортын ачааны тээвэрт ашиглах, дамжин өнгөрүүлэх вагоны тоог /ачаатай болон хоосон вагон урсгалын диаграмм/ төрөл бүрээр гаргаж ирүүлэхийг хүссэн албан бичиг явуулж, вагон урсгалын диаграммыг хүлээн авч судалгаанд ашиглаж байна.

Түрээсээр хөдлөх бүрэлдэхүүн эзэмшиж ашигладаг байгууллагуудын жагсаалт, түрээсийн вагоны жагсаалт гаргаж төвийн удирдлагад танилцуулсан.

Хөдлөх бүрэлдэхүүн түрээслэгч байгууллагуудаас хаанаас ямар ачаа хаана хүргэхэд ачааны төрөл, барааг хаанаас хаашаа тээвэрлэсэн, тээвэрт оролцох хугацааг дунджаар /хоног, цагаар/ тайланг авсан. Одоо түрээслэгч байгууллагуудыг гэрчилгээжүүлэх эсхүл тохирлын гэрчилгээ олгох тал дээр судалгаа хийж байна. Мөн гадаад улсад хэрэгжүүлж буй хууль эрх зүйн тал дээр судалгаа хийж байна.




Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт



2020 оны долоодугаар сард 69.6 мян.зорчигч 2485.3 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.


Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/



2020 оны долоодугаар сард 412.2 мян.тн ачаа дамжин өнгөрсөн байна.

Ачилтаар 2020 оны долоодугаар сард төмрийн хүдэр, зэс, молибдений баяжмал, жонш өссөн үзүүлэлттэй байна. Нийт 1797 мян.тн ачсан

Ачилт- ачааны төрлөөр /2020 оны 7 дугаар сард/






Нүүрс	27%
Төмрийн хүдэр	39%
Бусад ачаа	10%
Барилгын материал	15%
Жонш	3%
Зэс, молибдений баяжмал	3%
Нефтийн бүтээгдэхүүн	3%

2020 оны 7 дугаар сард өссөн дүнгээр 1142.12 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс -26.3-аар буурсан, 16905 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 8.4%-аар өссөн үзүүлэлттэй байна.



ИНФОГРАФИК





“ГТХЗНТ” УТУГ-ын Захирал БНСУ-ын “КОЙКА” олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Монгол Улс дахь суурин төлөөлөгчийг хүлээн авч уулзав.

“ГТХЗНТ” УТУГ-ын захирал А.Буяннэмэх 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдөр БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Монгол Улс дахь суурин төлөөлөгч, төслийг удирдагч Жү Хэйн-Наныг хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар хамтран хэрэгжүүлэх “Төмөр замын аюулгүй байдлын хяналт удирдлагын систем нэвтрүүлэх, Монгол Улсын төмөр замын стратегийн шинэчлэлт” төслийн талаар санал солилцов. БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /КОЙКА/-ийн суурин төлөөлөгч төслийн төлөвлөлтийн судалгааг 2020 оны 09 дүгээр сард эхлэхээр төлөвлөөд байгааг онцлов.



Мэдээ, мэдээлэл



“Мэдээллийн технологи” чиглэлээр 2.5 жилийн магистрын эчнээ хөтөлбөрийн хэлний сургалт үргэлжилж байна.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв нь Эрхүү хотын зам харилцааны их сургуультай хамтран “Мэдээллийн технологи” чиглэлээр 2.5 жилийн магистрын эчнээ хөтөлбөрт бүртгүүлсэн инженерүүдийн хэлний бэлтгэлийн сургалтыг эхлүүллээ. Сургалтыг Эрхүү хотын зам харилцааны их сургуулийн багш нар онлайнаар зааж байгаа бөгөөд төмөр замын салбарын инженер болон мэдээлэл технологийн инженерүүд хамрагдаж байна.



Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл болон бусад ажил

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 04-р сарын 21-ний өдрийн А/81 тоот тушаалаар Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгохтой холбоотой зарим эрх үүргийг гэрээний үндсэн дээр “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-т шилжүүлсэн.

2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрөөс тусгай зөвшөөрлийн материалыг анх хүлээж авч эхэлсэн. 2020.05.28-наас 2020.08.21-ны өдрийг хүртэл нийт 36 компанийн хүсэлт ирүүлснээс шинээр тусгай зөвшөөрөл авах 35 компани, сунгах хүсэлт гаргасан 1 компанийн материалыг хүлээн авч шийдвэрлэсэн. Үүнээс ажлын хэсгийн хурлын шийдвэрээр дэмжигдсэн 23 компани, буцаагдсан 5 компани, материалын бүрдэл дутуу 5 компани, шинээр материалаа ирүүлсэн 3 компани байна.

“Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горим” боловсруулан хяналтын шатандаа явагдаж байна.

Суурь бүтцүүд хоорондын галт тэрэг солилцоонд хагас жилийн байдлаар дүн шинжилгээ хийсэн.



Шинэ төмөр замуудын холболт, төмөр замын технологийн барилга байгууламжийн төлөвлөлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд томилолтоор ажиллаа.

ЗТХСайдын 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн А/130 дугаар тушаалаар байгуулагдсан Гашуунсухайт–Тавантолгой, Тавантолгой–Зүүнбаян–Сайншанд, Сайншанд–Баруун-Урт–Хөөт чиглэлийн төмөр замуудын холболт, Дорноговь, Өмнөговь аймгийн бүс нутаг дахь шинэ төмөр замын технологийн барилга байгууламжийн төлөвлөлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдөр Өмнөговь аймгийн Цогтцэций суман дахь өртөөдийн байршил, технологийн барилга байгууламжийн төлөвлөлтөд шинжилгээ хийх, төгсгөлийн өртөөдийн болон төмөр замуудын холболтын цэгийг тодорхойлох, 08 дугаар сарын 07-ны өдөр Дорноговь аймгийн Сайншанд суманд Тавантолгой–Зүүнбаян–Сайншанд–Баруун-Урт чиглэлийн төмөр замуудын холболт, технологийн байгууламжийн төлөвлөлтийг тодорхойлох зорилгоор газар дээр нь судалгаа хийж, оновчтой хувилбаруудыг боловсруулан дүгнэлт гарган ажилласан.





“ГТХЗНТ” УТҮГ нь Монголын Тээвэр Зуучлагчдын Нэгдсэн холбоотой санамж бичиг байгууллаа .

“ГТХЗНТ” УТҮГ-ы захирал А.Буяннэмэх МТЗНХ-н Удирдах зөвлөлийн дарга П.Солонго нар 2020.08.13-ны өдөр "Хамтын ажиллагааны санамж бичиг"-т гарын үсэг зурлаа. Улмаар талууд төмөр замын тээвэр зуучлал, логистикийн салбарыг хөгжүүлэх, зардлыг бууруулах арга замуудыг тодорхойлж ажил хэрэг болгохыг шуурхайлах, салбарын системийн мэдээлэл технологийн тал дээр идэвхи гарган ажиллахаар санал нэгдэв.





2019 онд Горький төмөр зам нь зорчигч, ачаа тээврийн хэрэгслийн эрэлт хэрэгцээг бүрэн хангаж, бүх хоорондын зам дээр галт тэргийг саадгүй хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэв.

Нөөц эрчим хүчийг хэмнэх технологийг идэвхтэй ашиглах, тээвэр, ложистикийн нэгдсэн үйлчилгээг хөгжүүлэх ажил нь үр дүнтэй болсон. Нэг цонхны үйлчилгээний зарчмаар ачааны эзэдтэй үр дүнтэй харилцах ажлыг зохион байгуулж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг татан, сүлжээгээ өргөжүүлж, үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаа сайжирсаар байна.



Оросын төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр үйлдвэрлэлийн үзүүлэлтүүд өмнөх онуудаас эрс өссөн байна. 2019 онд Горький төмөр замыг хөгжүүлэхэд 34 тэрбум рубль зарцуулжээ.


Хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг 60 ширхэг “Эрмак” загварын ачааны цахилгаан зүтгүүр, 20 ширхэг “2TE25K” загварын ачааны зүтгүүр, 5 ширхэг “EP3D” цахилгаан галт тэрэг, 5 ширхэг “РА3” төмөр замын автобус худалдан авж, зүтгүүрийн хөдлөх бүрэлдэхүүнийг сайжруулахад зарцуулсан. Шинэ зүтгүүрүүд нь галт тэрэгний массыг ихэсгэх, гол шугамын даацыг нэмэгдүүлэх, эрчим хүчний хэмнэлт, зүтгүүрийн чанарыг сайжруулсан.





2019 онд Балезино өртөөний дэд бүтцийг шинэчлэх ажлын хүрээнд хоёр шинэ зам ашиглалтанд оруулсан байна.

Үүнээс гадна замын дэд бүтцийн цогцолбор, "РЖД" ХК-ийн томоохон төслийн хүрээнд "Хоёр дахь зам барих, өртөөний замыг өргөтгөх, Баруун хойд зүгийн боомтод хүрэх төмөр замын уулзвар, хилийн өртөө байгуулах" мөн өртөөнүүдийг микропроцессор төвлөрөлд шилжүүлэх, Балезино, Лянгасово өртөөнүүдийг сэргээн барих зураг төсөл, судалгааны ажил хийгдэж байна. Хөрөнгө оруулалтын дараагийн төсөл нь "Транссибирийн төмөр замаар дамжин өнгөрөх контейнерын ачааг 4 дахин нэмэгдүүлэх дэд бүтцийн арга хэмжээ юм.



Юдино өртөөг хөгжүүлэх, Дербишки-Арск хэсгийн 53 км урт гурав дахь замыг барих, Зуевка өртөөний хүлээн авах, гарах хоёр замыг өргөтгөсөн. Зуевка өртөөний хүлээн авах, гарах хоёр замыг өргөтгөж, нийт 164.3 км урт төмөр замын замыг шинэчлэх ажил дуусжээ.

1917 онд баригдаж, 1987 онд их засвар хийгдэж байсан Пудлинговый-Черная Речка, Красноуфимск-Саранинский Завод гэсэн хэсгүүдэд хоёр төмөр замын хонгил барьж, шинэ объект бий болгосон.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөрт тусгагдсан, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хэд хэдэн төсөл хэрэгжиж дууслаа. Лянгасова өртөөнд галт тэрэг болон вагоны ачаа тээврийн коммерцийн үзлэгийн автоматжуулсан систем нэвтрүүлсэн.



2019 онд замын дэд бүтцийг хөгжүүлэхэд Оросын төмөр замууд 24.7 тэрбум рублийн хөрөнгө оруулалт хийжээ.

Тус зам нь Баруун хойд ай сав газрын боомтуудын чиглэлд, ялангуяа Ярославль-Главный Александров, Вологда-Данилов, Вологда-Череповец, Вологда-Коноша, Нядома-Обозерская зэрэг ачаалал өндөртэй хэсгүүдээр дамжин өнгөрөх ачааны бөөгнөрөл, ачааллыг багасгасан байна.

ОХУ-ын "РЖД" ХК нь "Баруун хойд зүгийн боомт хүртэлх өртөөний замыг өргөтгөх, хоёр дахь замыг барих" төслийн хүрээнд Вологда II өртөөний Баруун паркад хоёр замыг уртасгахаас гадна, Лоста өртөөний дамжин өнгөрөх парк дээр, Коноша I ба Буй уулзварын өртөөн дээрх замуудыг уртасгасан.



Череповец II өртөөг сэргээн барих ажил үргэлжилж байна. Гурван шинэ, одоо байгаа 13 хүлээн авах, гарах замын өргөтгөлийг цаашид үргэлжлүүлэн сэргээн барихаар төлөвлөж байна.



**Газар бизнес төвийн байр,
Тээвэрчдийн гудамж,
2-р хороолол, 1-р хороо,
Баянгол дүүрэг, 16052,
Улаанбаатар хот, Монгол улс**

